



ХАН-УУЛ ДҮҮРГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ДАРГЫН ТУШААЛ

2017 оны 11 сарын 13 өдөр

Дугаар А/106.

Улаанбаатар хот


Сүрьеэ, бэлгийн замаар дамжих халдвараас
сэргийлэх, хянах үйл ажиллагааг
эрчимжүүлэх тухай

Монгол улсын Засгийн газрын 2017 оны “Халдварт өвчнөөс сэргийлэх, хянах үндэсний хөтөлбөр батлах тухай” 11 дүгээр тогтоол, Эрүүл Мэндийн Сайдын 2017 оны “Сүрьеэгийн тусламж үйлчилгээг сайжруулах зарим арга хэмжээний тухай” 306, “Журам заавар батлах тухай” 305 дугаар тушаалууд, Нийслэлийн Эрүүл мэндийн газрындаргын 2017 оны 2/659 албан тоотоор ирсэн зөвлөмжийг үндэслэн ТУШААХ нь.

1. Сүрьеэ, бэлгийн замаар дамжих халдвараас урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийг эрчимжүүлэх ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, 2017-2018 онд хийх ажлын төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Харьяа хороо, хүүхдийн байгууллагын хавьтлын урьдчилан сэргийлэх үзлэг, эрт илрүүлэгт ажиллах мэргэжилтнүүдийн ажлыг зохицуулж, шаардлагатай хүн хүчээр хангаж ажиллахыг поликлиник болон яармаг салбарын эрхлэгч, Өрхийн Эрүүл мэндийн төвийн дарга нарт үүрэг болгосугай.
3. Төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайланг хагас бүтэн жилээр гаргаж тархвар судлаач /Ө.Ариунжаргал/-д ирүүлэхийг сүрьеэ БЗДХ/ДОХ ХДХВ зохицуулагч нар, Өрхийн Эрүүл мэндийн төвийн дарга нарт үүрэг болгосугай.
4. Уг тушаалын дагуу хийсэн ажлын тайланг хагас бүтэн жилээр гарган Нийслэлийн Эрүүл мэндийн газрын Нийгмийн эрүүл мэндийн хэлтэст хүргүүлэхийг тархвар судлаач /Ө.Ариунжаргал/-д даалгасугай.
5. Сүрьеэ, бэлгийн замаар дамжих халдвараас сэргийлэх үйл ажиллагааг ард иргэдэд түгээх, урьдчилан сэргийлэх мэдээлэл, ярилцлага, зөвлөмж, сэрэмжлүүлэг, зурагт хуудсыг олон нийтэд хүргэж ажиллахыг Сургалт хариуцсан арга зүйч /Б.Эрдэнэсүвд/-д үүрэг болгосугай.
6. Энэхүү тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг нийгмийн эрүүл мэндийн орлогч дарга /Б.Лувсанням/-д даалгасугай.


ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Э.БОДЬЦЭЦЭГ



170 70 0973

Хан-Уул дүүргийн Эрүүл мэндийн төвийн
даргын 2017 оны сарын өдрийн
.... тоот тушаалын нэгдүгээр хавсралт



СҮРЬЕЭ, БЭЛГИЙН ЗАМААР ДАМЖИХ ХАЛДВАРААС
УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ЭРТ ИЛРҮҮЛГИЙГ ЭРЧИМЖҮҮЛЭХ
АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч: Б.Лувсанням / Нийгмийн эрүүл мэндийн орлогч дарга/

Ажлын хэсгийн нарийн бичиг: Ө.Ариунжаргал /Тархвар судлаач/

Ажлын хэсгийн гишүүд: Л.Нарангэрэл /Сүрьеэ диспансерийн зохицуулагч /

Б.Ундармаа /БЗДХ/ХДХВ/ДОХ-ын ахлах эмч/


Ц.Оюунчимэг /Чанарын менежер /

Ё.Бумдарь /Лабораторийн эрхлэгч/

О.Тунгалаг /Өсвөр үеийн кабинетийн эмч/

Өрхийн эрүүл мэндийн төвийн дарга нар

Хан-Уул дүүргийн Эрүүл мэндийн төвийн
даргын 2017 оны 11 сарын 13 өдрийн
А/ тоот тушаалын хоёрдугаар хавсралт



**СҮРЬЕЭ, БЭЛГИЙН ЗАМААР ДАМЖИХ ХАЛДВАРААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ,
ЭРТ ИЛРҮҮЛГИЙГ ЭРЧИМЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР 2017-2018 ОНД
ХИЙХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хугацаа	Хариуцах алба нэгж, албан тушаалтан
1. Дүүргийн эрүүл мэндийн төв			
1.1	Сүрьеэ, БЗДХ/ХДХВ-ийн кабинетийн тархвар судлаач эмч нарыг нэгдсэн эмнэлгийн бүтэц үйл ажиллагааны стандартад заагдсан орон тоогоор ажиллуулах	2017- 2018	Хүний нөөцийн алба
1.2	Сүрьеэ, БЗДХ, ХДХВ, ДОХ-ын идэвхтэй эрт илрүүлгийг нийт хүн амын дунд тогтмол зохион байгуулж, өвчлөлийн тохиолдлыг эрт илрүүлж, төгс эмчлэх	Тогтмол	Сүрьеэ диспансер, БЗДХ/ХДХВ/ДОХ-ын кабинет
1.3	Сүрьеэ, БЗДХ-ын оношлогоонд тулгамдаж буй асуудлыг тодорхойлон чанарыг сайжруулах	11-12 сар	Чанарын алба, лабораторийн эрхлэгч
1.4	Дүүргийн сүрьеэ диспансер, БЗДХ/ХДХВ/ДОХ-ын кабинет, ӨЭМТ-үүдийн нэг цэгийн үйл ажиллагаанд чанарын хяналт хийж, үйл ажиллагааг сайжруулах	11-12 сар	Чанарын алба
1.5	Жирэмсний хяналтанд онцгойлон анхаарч төрөлхийн тэмбүүгийн тохиолдлыг бууруулах, нэг цэгийн үйл ажиллагааг тогтмолжуулах, чанаржуулах	Тогтмол	Эмэгтэйчүүдийн ахлах эмч, БЗДХ/ХДХВ/ДОХ-ын кабинет
1.6	Хавьтлын илрүүлэг, хяналтыг чанаржуулах, судалгааг нарийвчлан гаргах	Тогтмол	Тархвар судлаач, Сүрьеэ диспансер, БЗДХ/ХДХВ/ДОХ-ын кабинет, ӨЭМТ
1.7	Төрийн болон хувийн өмчийн хүүхдийн байгууллагад гарсан өвчлөлд дүн шинжилгээ хийж голомтыг илрүүлэх ажлыг эрчимжүүлэх	Тогтмол	Тархвар судлаач, Сүрьеэ диспансер, БЗДХ/ХДХВ/ДОХ-ын кабинет, ӨЭМТ
1.8	Их дээд сургууль, коллеж, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвд суралцагсад болон ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдыг сүрьеэ, БЗДХ/ХДХВ/ДОХ-оос урьдчилан сэргийлэх үзлэгт бүрэн сайжруулах ажлыг жил бүр зохион байгуулах	4 –р улирал	Өсвөр үеийн кабинет, Сүрьеэ диспансер, БЗДХ/ХДХВ/ДОХ-ын кабинет, ӨЭМТ
1.9	Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдаас сүрьеэ, БЗДХ/ХДХВ/ДОХ-оос сэргийлэх чиглэлээр үе тэнгийн сургагч бэлтгэх, үр дүнг тооцох	2,4-р улиралд	Өсвөр үеийн кабинет, Сүрьеэ диспансер, БЗДХ/ХДХВ/ДОХ-ын кабинет

1.10	ӨЭМТ, дүүргийн сүрьеэгийн эмч, тархвар судлаачдад эмнэлзүй, халдварын тандалт, илрүүлэг, урьдчилан сэргийлэлт, зөвлөгөө өгөх арга барилын чиглэлээр чадавхжуулах сургалтыг зохион байгуулах	11-12 сар	БЗДХ/ХДХВ/ДОХ-ын кабинет, ӨЭМТ
1.11	Харьяа нутаг дэвсгэр дээр байрлах аж ахуйн нэгж байгууллага, олон нийтэд чиглэсэн сургалт, сурталчилгааг өргөжүүлэх	Тогтмол	Сүрьеэ диспансер, БЗДХ/ХДХВ/ДОХ-ын кабинет, ӨЭМТ

2. Өрхийн эрүүл мэндийн төвүүд

2.1	Хорооны цагдаа, нийгмийн ажилтан, хэсгийн ахлагчтай хамтарч ажиллахдаа жирэмсний хяналт, сүрьеэ, БЗДХ/ХДХВ/ДОХ-ын холбоотой асуудлаар өвчтний нууцыг хадгалахад анхаарах	Тогтмол	ӨЭМТ-ийн дарга нар
2.2	Эрсдэлт бүлгийн иргэдийн судалгааг хагас жил тутам шинэчлэх	2, 4 улирал	ӨЭМТ-ийн дарга нар
2.3	Нийт хүн ам болон эрсдэлт бүлгийн иргэдийн дунд идэвхтэй эрт илрүүлгийг тогтмол зохион байгуулж, сүрьеэ, БЗДХ, ХДХВ, ДОХ-ын тохиолдлыг эрт илрүүлэх, эмчлэх	Тогтмол	ӨЭМТ-ийн адарга нар Сүрьеэ диспансер, тархвар судлаач, БЗДХ/ХДХВ/ДОХ-ын кабинет, ӨЭМТ
2.4	Хавьтал илрүүлэг дээр онцгой анхаарч, хяналтыг чанаржуулах, судалгааг нарийвчлан гаргах	Тогтмол	ӨЭМТ-ийн дарга нар Сүрьеэ диспансер, тархвар судлаач, БЗДХ/ХДХВ/ДОХ-ын кабинет, ӨЭМТ
2.5	Жирэмсний хяналтын чанарыг сайжруулж, төрөлхийн тэмбүүгийн тохиолдлын тоог бууруулах, нэг цэгийн үйл ажиллагааг тогтмолжуулах, чанаржуулах	Тогтмол	ӨЭМТ-ийн дарга нар
2.6	Тэмбүү илрүүлэх хурдавчилсан сорилоор тасралтгүй хангах, сорил эерэг тохиолдлын эмчилгээ, хяналтыг чанартай хийх	Тогтмол	ӨЭМТ-ийн дарга нар, дүүргийн эрүүл мэндийн төвийн эмэгтэйчүүдийн болон БЗДХ-ын эмчтэй хамтран хэрэгжүүлэх
2.7	Шууд хяналттай богино хугацааны эмчилгээний чанарыг сайжруулах үйл ажиллагаанд явуулын явуулын тусламж үйлчилгээ зэрэг идэвхтэй аргыг ашиглах	Тогтмол	ӨЭМТ-ийн дарга нар
2.8	Нийт иргэдэд чиглэсэн сургалт сурталчилгааг өргөжүүлэх, эрт илрүүлгийн ач холбогдлыг ойлгуулахад чиглэсэн зан үйлийг өөрчлөх харилцааг мэдээллийн боломжит бүх сувгаар явуулах	тогтмол	ӨЭМТ-ийн дарга нар